



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/392

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.5, Сангийн сайдын 2018 оны 318 тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 2.1.4 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” 46 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/430 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батширээт, Биндэр сумын нутагт орших Гутайн даваа-Хөмүүл голын эхийг байгалийн цогцолборт газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авсантай холбогдуулж “Айвуун тэс” ХХК-ны MV-002247 тусгай зөвшөөрлийн дугаартай “Гутай” нэртэй талбай, “Пегматит майнинг” ХХК-ны MV-019023 тусгай зөвшөөрлийн дугаартай “Шургадагийн гол” нэртэй талбайд ашиглаж байгаа уул уурхайн машин механизм, тоног төхөөрөмжийг тусгай хамгаалалттай газар нутгаас гаргах, ажилчдын тосгоныг буулгаж, нүүлгэх шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Дархантөр

Байгаль орчин, аялал, жуулчлалын газрын
дарга

Нарийн бичгийн
дарга:

Г.Мөнх-Эрдэнэ

Байгаль орчин, аялал, жуулчлалын газрын
мэргэжилтэн

Гишүүд:

Б.Энхбат

Цагдаагийн газрын экологийн асуудал
хариуцсан эрүүгийн мөрдөгч, Цагдаагийн
ахмад

Д.Шараа

Мэргэжлийн хяналтын газрын Геологи уул
уурхайн хяналтын улсын байцаагч

Л.Эрээнтовч
Б.Бат-Эрдэнэ

Тагнуулын хэлтсийн ажилтан Ахлах дэслэгч
Онцгой байдлын газрын Гамшгаас
хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч

О Цэндгомбо

Онон балжийн байгалийн цогцолборт
газрын хамгаалалтын захиргааны дарга

2.

М.Болд

Батширээт сумын Засаг дарга

2. Нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой гарах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

4. Нүүлгэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулж 2020 оны 06 дугаар сарын 25-ны дотор тайлагнахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Шатахууны зардал /Урал/						
Д/д	Сумдын нэр	км	Шатахууны зарцуулалт /литр/	Шатахуун литр /Дизль/	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Батширээт-Гутай	80	35	28	2200	61600
2	Гутай-Батширээт	80		28	2200	61600
Нийт		160		56		123200

Шатахууны зардал /Караз/						
Д/д	Сумдын нэр	км	Шатахууны зарцуулалт /литр/	Шатахуун литр /Дизль/	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Батширээт-Гутай	80	35	28	2200	61600
2	Гутай-Батширээт	80		28	2200	61600
Нийт		160		56		123200

Хоол хүнс, бээлий				
Д/д	Нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хоол	36 ш	6700	241000
2	Замын хүнс			80000
Нийт				321000

Д/д	Ажлын гүйцэтгэл	Нийт дүн
1	Трайлер машин түрээсийн зардал	3500000
2	Өрөө өргөгч түрээсийн зардал	310000
Нийт		3810000

Нийт зардал

Д/д	Ажлын гүйцэтгэл	Нийт дүн
1	Шатахууны зардал	246400
2	Хоол хүнс/ бээлий/	321000
3	Ажлын хөлс	3810000
Нийт		4377400